



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2013 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Г
Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн 6.4-6.7, 9.4.дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Тамхины хайрцаг, сав, баглаа боодол дээр хэвлэх тамхины хэрэглээнээс хүний эрүүл мэндэд учрах хор хөнөөлийг харуулсан тайлбар бүхий эрүүл мэндийн зурагт анхааруулгыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 36 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн зурагт анхааруулга, түүний тайлбарт тавигдах шаардлага”-ын “3.”, “4.1.” дэх заалтыг хасч, 5 дахь заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

“...5. Янжуур болон дүнсэн тамхины хайрцаг, сав, баглаа боодол дээр байрлах эрүүл мэндийн зурагт анхааруулгын “тайлбар”-т тавигдах шаардлага:

5.1. Эрүүл мэндийн зурагт анхааруулгын тайлбар дараахь 6 төрөлтэй байна:

- 5.1.1. Тамхи гоо сайханыг гутаана.
- 5.1.2. Тамхи хорт хавдар үүсгэнэ.
- 5.1.3. Тамхи бэлгийн сурвал үүсгэнэ.
- 5.1.4. Тамхи үхжил үүсгэнэ.
- 5.1.5. Тамхи үхлийн хор мөн.
- 5.1.6. Тамхи ургийн гаж хөгжил үүсгэнэ.

5.2. Эрүүл мэндийн зурагт анхааруулгын тайлбар:

5.2.1. 1 дүгээр зургийн тайлбар: “Тамхи гоо сайхныг гутаана.” гэсэн бичиглэлийн “Тамхи...”, “...гутаана.” гэсэн бичиглэлийг компьютерийн “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “12” хэмжээгээр, “гоо сайхныг” гэсэн фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “16” хэмжээгээр бичиглэлийг “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “20” хэмжээгээр бичиж, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу цагаан дэвсгэр дээр улаанаар бичнэ.

5.2.2. 2 дугаар зургийн тайлбар: “Тамхи хорт хавдар үүсгэнэ.” гэсэн бичиглэлийн “Тамхи...”, “...үүсгэнэ.” гэсэн бичиглэлийг компьютерийн “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “14” хэмжээгээр, “хорт хавдар” гэсэн фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “20” хэмжээгээр бичиглэлийг “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “20” хэмжээгээр бичиж, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.

5.2.3. 3 дугаар зургийн тайлбар: “Тамхи бэлгийн сулрал үүсгэнэ.” гэсэн бичиглэлийн “Тамхи...”, “...үүсгэнэ.” гэсэн бичиглэлийг компьютерийн “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “12” хэмжээгээр, “бэлгийн сулрал” гэсэн бичиглэлийг “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “18” хэмжээгээр бичиж, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.

5.2.4. 4 дүгээр зургийн тайлбар: “Тамхи үхжил үүсгэнэ.” гэсэн бичиглэлийн “Тамхи...”, “...үүсгэнэ.” гэсэн бичиглэлийг компьютерийн “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “14” хэмжээгээр, “үхжил” гэсэн бичиглэлийг “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “20” хэмжээгээр бичиж, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.

5.2.5. 5 дугаар зургийн тайлбар: “Тамхи- үхлийн хор мөн.” гэсэн бичиглэлийн “Тамхи...”, “...мөн.” гэсэн бичиглэлийг компьютерийн “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “14” хэмжээгээр, “үхлийн хор” гэсэн бичиглэлийг “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “18” хэмжээгээр бичиж, зургийн дээд хэсгийн ирмэг дагуу шар өнгөөр бичнэ.

5.2.6. 6 дугаар зургийн тайлбар: “Тамхи ургийн гаж хөгжил үүсгэнэ.” бичиглэлийн “Тамхи ургийн...”, “...үүсгэнэ.” гэсэн бичиглэлийг компьютерийн “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “12” хэмжээгээр, “гаж хөгжил” гэсэн бичиглэлийг “Arial”-фондын, “bold” хэлбэр, жижиг үсгийн “18” хэмжээгээр бичиж, зургийн баруун дээд хэсэгт шар өнгөөр бичнэ.

3. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 2 дугаар сарын 4-ний 36 тоот тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэндийн сайдын 2013 оны
04. дүгээр сарын 17-ний өдрийн 14.6
тоот тушаалын наст дүгээр
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗУРАГТ АНХААРУУЛГА, ТҮҮНИЙ ТАЙЛБАР

Зурагт анхааруулга №1



Зурагт анхааруулга №2



Зурагт анхааруулга № 3



Зурагт анхааруулга №4



Зурагт анхааруулга №5



Зурагт анхааруулга № 6

